

2026 он 3 сар 19 өдөр

№ 26/06

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан Зээлийн гэрээнд үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор Ард Актив ХЗХ болон Компани хооронд байгуулсан батлан даалтын гэрээний хугацаанд өөрчлөлт оруулахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулан компанийг төлөөлж холбогдох баримт бичиг, батлан даалтын гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Уянгад, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудит эрхэлсэн захирал М.Мөнх-Эрдэнэд тус тус **ОЛГОСУГАЙ.**
3. Сонирхлын зөрчилгүй буюу хараат бус гишүүд шийдвэр гаргасан болохыг **ДҮРДСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 3 сарын 19-ны өдрийн
26/06 тоот тогтоолын хавсралт 1

Доорх зээлийн гэрээний хугацааг сунгагдаж байгаатай холбоотой Компани батлан даалтын гэрээг 1 жилээр сунгаж, баталгаажуулах:

Зээлдэгчийн нэр	Бүт.нэр	Олгосон	Дуусах	Олгосон дүн	Хүү
АРД ЛИЗИНГ ХХК	БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 365	2024.03.29	2026.03.29	480,000,000	22
АРД ПРОПЕРТИЗ ХХК	БИЗНЕСИЙН ЗЭЭЛ 365	2024.04.09	2026.04.09	1,516,000,000	22